



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгонтэнгэр рашаан сувилалын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/118/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.6.1 Төсвийн төлөвлөлт	15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.6.3 Нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	16
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	16
4.2.1 Залруулсан алдаа.....	17
4.2.2 Төлбөрийн акт.....	17
4.2.3 Албан шаардлага	17
4.2.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1. Аудитын санал дүгнэлт



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1302/136

танай _____ -ны № _____ -т

ОТГОНТЭНГЭР РАШААН СУВИЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЦОЛМОН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Отгонтэнгэр рашаан сувилалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгонтэнгэр рашаан сувилалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022070

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	/мянган төгрөг/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>130,671.11</u>	<u>91,972.95</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,771.00	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	500.00	-
Төгрөг	500.00	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,271.00	-
Төгрөг	1,271.00	-
Төрийн сангийн харилцах	1,271.00	-
АВЛАГА	3,108.39	23,956.51
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,500.19	23,946.25
Бусад авлага	608.20	10.26
Байгууллагаас авах авлага	608.20	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	10.26
УРЬДЧИЛГАА	-	21,000.00
Урьдчилгаа тооцоо	-	21,000.00
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	21,000.00
БАРАА МАТЕРИАЛ	125,791.72	47,016.44
Түүхий эд материал	23,940.20	19,041.30
Тусгай зориулалттай материал	22,209.13	17,349.95
Эм боох материал	1,731.07	1,691.35
Хангамжийн материал	101,851.52	27,975.14
Бичиг хэргийн материал	483.60	489.80
Аж ахуйн материал	38,862.94	17,670.74
Түлш, шатах тослох материал	12,370.60	5,691.60
Барилгын засварын материал	49,711.38	3,891.00
Хүнсний материал	191.00	-
Бусад хангамжийн материал	232.00	232.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>115,121.92</u>	<u>109,683.19</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	115,121.92	109,683.19
Биет хөрөнгө	45,679.92	40,241.19
Барилга, байгууламж, орон сууц	112,599.60	112,599.60
Хуримтлагдсан элэгдэл	(110,266.27)	(110,932.93)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,932.39	29,932.39
Хуримтлагдсан элэгдэл	(18,976.12)	(22,546.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,762.88	49,762.88
Хуримтлагдсан элэгдэл	(17,851.69)	(23,053.45)
Бусад үндсэн хөрөнгө	9,816.00	9,816.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,496.00)	(5,496.00)
Ном	159.12	159.12
Биет бус хөрөнгө	69,442.00	69,442.00
Бусад биет бус хөрөнгө	69,442.00	69,442.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>245,793.03</u>	<u>201,656.13</u>

НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>42,682.95</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	42,682.95
Өглөг	-	42,682.95
Ажилчидтай холбогдсон өглөг	-	14,689.07
Бусад өглөг	-	27,993.88
Байгууллагад төлөх өглөг	-	21,239.78
Хувь хүмүүст төлөх өглөг	-	6,754.10
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>245,793.03</u>	<u>158,973.18</u>
Засгийн газрын хувь оролцоо	245,793.03	158,973.18
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,301.26	211,301.26
Өмч: - төрийн	211,301.26	211,301.26
Хуримтлагдсан үр дүн	33,456.80	(53,363.05)
Өмнөх үеийн үр дүн	33,456.80	22,581.80
Тайлант үеийн үр дүн	-	(75,944.85)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,034.97	1,034.97
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>245,793.03</u>	<u>201,656.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	341,562.65	108,520.05
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,865.15	16,520.05
Нийтлэг татварын бус орлого	112,865.15	16,520.05
Төсөв байгууллагын өөрийн орлого	112,865.15	16,520.05
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,945.15	16,014.26
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,920.00	505.79
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	228,697.50	92,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	19,442.10	15,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,442.10	15,000.00
Төсвийн захирагчдаас	-	5,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	5,000.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	209,255.40	72,000.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	209,255.40	72,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	296,461.25	184,464.90
УРСГАЛ ЗАРДАЛ	296,461.25	184,464.90
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,398.20	178,359.80
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,332.88	48,572.00
Үндсэн цалин	142,332.88	48,572.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,178.66	6,306.64
Тэтгэврийн даатгал	11,852.73	3,950.52
Тэтгэмжийн даатгал	1,394.44	511.81
ҮОМШӨ-ний даатгал	1,115.55	106.32
Ажилгүйдлийн даатгал	144.23	1,036.22
Эрүүл мэндийн даатгал	1,671.70	701.76

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,524.88	4,766.10
Гэрэл, цахилгаан	429.48	766.10
Түлш, халаалт	8,450.40	-
Байрны түрээс	1,645.00	4,000.00
Хангамж, бараа материалын зардал	17,157.17	41,342.49
Бичиг хэрэг	2,179.16	1,435.92
Тээвэр, шатахуун	2,186.29	9,582.86
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	437.50	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205.00	140.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,149.22	6,053.92
Бараа материал акталсны зардал	-	24,129.79
Нормативт зардал	61,725.17	18,459.36
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,600.87	3,037.31
Хоол, хүнс	57,124.30	15,422.05
Эд хогшил, урсгал засварын зардал	13,089.22	47,591.38
Урсгал засвар	13,089.22	47,591.38
Томилолт, зочны зардал	1,815.00	-
Дотоод албан томилолт	1,815.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,333.40	1,883.10
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,620.30	-
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	576.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	896.50
Газрын төлбөр	1,024.60	410.60
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148.50	-
Бараа үйлчилгээний бусад зардал	9,241.82	9,438.73
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,241.82	9,438.73
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,063.05	6,105.10
Бусад урсгал шилжүүлэг	100.00	6,103.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100.00	6,103.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43.05	2.10
Төвлөрүүлэх шилжүүлэг	43.05	2.10
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,920.00	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	17,920.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>45,101.40</u>	<u>(75,944.85)</u>
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>45,101.40</u>	<u>(75,944.85)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,301.26	1,034.97	(63,351.41)	148,984.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,301.26	1,034.97	(63,351.41)	148,984.82
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	34,866.53	34,866.53
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,301.26	1,034.97	33,456.80	245,793.03
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,301.26	1,034.97	33,456.80	245,793.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(10,875.00)	(10,875.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,301.26	1,034.97	22,581.80	234,918.03
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(75,944.85)	(75,944.85)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,301.26	1,034.97	(53,363.05)	158,973.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>341,562.65</u>	<u>128,040.81</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,865.15	16,520.05
120	Нийтлэг татварын бус орлого	112,865.15	16,520.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	112,865.15	16,520.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,945.15	16,014.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,920.00	505.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	228,697.50	111,520.76
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,442.10	15,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,442.10	15,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,520.76
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	19,520.76
1330	Төсвийн захирагчдаас	-	5,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	5,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	209,255.40	72,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	209,255.40	72,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>334,942.65</u>	<u>125,811.81</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,942.65	125,811.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,799.60	119,706.71

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,295.20	76,656.39
210101	Үндсэн цалин	38,093.34	75,103.64
210102	Нэмэгдэл	42,531.36	1,552.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66.00	-
210104	Урамшуулал	4,604.50	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,514.90	4,500.00
210201	Тэтгэврийн даатгал	8,103.00	4,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	853.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	682.40	-
210204	Ажилгүйдлийн даатгал	170.60	-
210205	Эрүүл мэндийн даатгал	1,705.90	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,408.70	4,766.10
210301	Гэрэл, цахилгаан	740.00	766.10
210302	Түлш, халаалт	13,023.70	-
210304	Байрны түрээс	1,645.00	4,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,776.40	2,961.46
210401	Бичиг хэрэг	2,084.36	665.80
210402	Тээвэр, шатахуун	3,580.34	2,295.66
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	437.50	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	395.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,279.20	-
2105	Нормативт зардал	83,213.00	6,579.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,577.27	796.00
210502	Хоол, хүнс	55,590.59	5,783.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,045.14	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,417.30	1,771.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200.00	-
210604	Урсгал засвар	31,217.30	1,771.00
2107	Томилолт, зочны зардал	1,815.00	-
210702	Дотоод албан томилолт	1,815.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,359.10	22,472.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,646.00	21,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	576.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	896.50
210807	Газрын төлбөр	1,024.60	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148.50	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143.05	6,105.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	100.00	6,103.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100.00	6,103.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43.05	2.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43.05	2.10

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,620.00</u>	<u>2,229.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,120.00	4,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,120.00	4,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,120.00	4,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,120.00	4,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(6,120.00)</u>	<u>(4,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	500.00	(1,771.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,271.00	1,771.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,771.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	237,500.00	52,747.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	237,500.00	52,747.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,500.00	52,745.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,876.20	45,506.39
210101	Үндсэн цалин	30,748.30	43,953.64
210102	Нэмэгдэл	3,465.00	1,552.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,662.90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,518.30	-
210201	Тэтгэврийн даатгал	3,883.20	-
210202	Тэтгэмжийн даатгал	408.80	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	327.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	81.80	-
210205	Эрүүл мэндийн даатгал	817.50	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,408.70	766.10
210301	Гэрэл, цахилгаан	7,117.70	766.10
210302	Түлш, халаалт	6,767.00	-
210304	Байрны гүрээс	1,524.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	11,458.40	2,961.46
210401	Бичиг хэрэг	1,188.00	665.80
210402	Тээвэр, шатахуун	5,445.00	2,295.66
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	314.80	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,524.80	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,985.80	-

2105	Нормативт зардал	48,729.70	730.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,705.90	400.00
210502	Хоол, хүнс	25,532.10	330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,491.70	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,888.30	1,771.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,552.30	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,486.00	-
210604	Урсгал засвар	14,850.00	1,771.00
2107	Томилолт, зочны зардал	1,980.00	-
210702	Дотоод албан томилолт	1,980.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,640.40	1,010.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,002.60	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800.00	576.00
210803	Даатгалын үйлчилгээ	69.30	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79.20	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16.80	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	434.50
210807	Газрын төлбөр	2,524.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148.50	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2.10
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	2.10
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	237,500.00	31,455.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	15,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	15,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	237,500.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	237,500.00	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	71,131.80	16,455.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,131.80	15,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	505.79
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,771.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.005	0.005
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.003	0.003
620003	Үйлчлэх ажилтан	0.001	0.001
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.005	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	0.003	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	0.002	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,064.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,064.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,961.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,150.00
210101	Үндсэн цалин	31,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,500.00
210201	Тэтгэврийн даатгал	4,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,000.00
210304	Байрны түрээс	4,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000.00
2105	Нормативт зардал	5,849.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	396.00
210502	Хоол, хүнс	5,453.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,462.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	462.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,103.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,103.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,103.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,064.26
	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,000.00
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	72,000.00
	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС	5,000.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,000.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	64.26
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64.26

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Отгонтэнгэр рашаан сувилалын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Отгонтэнгэр рашаан сувилалын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 09-ны өдрийн №06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Отгонтэнгэр рашаан сувилал нь хүнлэг энэрэнгүй ёсыг дээдэлсэн чадварлаг менежменттэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, уламжлалт анагаах, сэргээн засах тусламж үйлчилгээний оношилгоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанарын өндөр төвшинд үзүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгонтэнгэр рашаан сувилалын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 86,131.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,292.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 968.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 260,206.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 4,135.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 70 хувь буюу 3,101.5 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,771.00	-	(1,771.0)
Авлага	3,108.39	23,956.51	20,848.12
Урьдчилгаа	-	21,000.0	21,000.0
Бараа материал	125,791.72	47,016.44	(78,775.28)
Үндсэн хөрөнгө	115,121.92	109,683.19	(5,438.73)
Нийт хөрөнгө	245,793.03	201,656.13	(44,136.90)
Өр төлбөр	-	42,682.95	42,682.95
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	245,793.03	158,973.18	(86,819.85)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	245,793.03	201,656.13	(44,136.90)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,771.0 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгө үлдэгдлийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 20,848.12 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан орон тоог 10 хүнээр нэмэгдүүлэн ажилласантай холбоотой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын санхүүжилтийг менежментийн удирдах баг “БОДУ” компаниас авлага болгон залруулга хийлгэсэнтэй холбоотой.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 21,000.0 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалтын шинжтэй их засварын ажлын төсвөөс “БОДУ” ХХК-д төлсөн төлбөрийг урьдчилж төлсөн төлбөрөөр залруулан бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,775.3 мянган төгрөгөөр буурсан нь 28,617.9 мянган төгрөгийн түүхий эд материал, хангамжийн материал болон эм боох материалууд худалдан авч, 83,263.4 мянган төгрөгийн хангамж, түүхий эд материал зарцуулж, 24,129.8

мянган төгрөгийн тусгай зориулалтын болон аж ахуйн материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,438.73 мянган төгрөгөөр буурсан нь 4,000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 9,438.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 42,682.95 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 14,689.1 мянган төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 10,875.0 мянган төгрөгийн өмнөх оны аудитын актын төлбөр, болон бусад байгууллага, хувь хүмүүст төлөх өглөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 86,819.85 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөр 15,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоор 71,131.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжихээр тооцон төлөвлөж, урсгал зардлыг 289,519.2 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 15,000.0 мянган төгрөгийн, өөрийн орлогоор 15,950.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 505.8 мянган төгрөг, нийт 31,455.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 52,747.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт санхүүжилт гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 72,000.0 мянган төгрөгийн, өөрийн орлогоор 64,300.0 мянган төгрөгийн, төсвийн захирагчдаас 5,000.0 мянган төгрөг нийт 77,064.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 70,961.3 мянган төгрөгийг зарцуулж, 6,103.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Батлагдсан орон тоог 10 ажилтнаар нэмэгдүүлж, орон тооны бус ажилчдад тэтгэмж, урамшуулал олгосон зөрчил илэрсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 147 мэдээ байршуулахаас 4 мэдээ хугацаа хоцроож цалингаас бусад 5 саяас дээш үнийн мэдээтэй мэдээллийг буруу мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10,875.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 21,562.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. Завхан аймгийн аудитын газарт актын төлбөрийг 2022 оны 06 сараас эхлэн төлөхөөр албан тоот хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 онд хэрэгжих үндсэн хөрөнгийн капиталжилт болон үндсэн хөрөнгийн өртгийн хүлээн зөвшөөрөлтийг нарийвчлан авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Засварын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 97,208.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 87,987.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,803.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,417.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 4,000.0 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 83,987.7 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ ЭМСайдын А/496 тушаал, ЭМЯамны 1а/3938 мөнгөн тэтгэмж олгох журмыг зөрчин үндсэн бус ажилчдад 1.7 сая төгрөгийн урамшуулал олгосон.
- ✓ Төсвийн тухай хууль 6-р зүйл, Засгийн газрын 43-р тогтоолыг зөрчин үндсэн бус ажилтанд 1.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3 заалтыг үндэслэн үндэслэлгүй олгосон урамшуулал, тэтгэмжийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

- ✓ 6,417.8 мянган төгрөгийн зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Отгонтэнгэр рашаан сувилал	7	97.2	4	88.0	2	2.8			1	6.4
	Дүн	7	97.2	4	88.0	2	2.8			1	6.4